



# СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК

Монголын МНБИ болон ТМЗН-ийн гишүүн байгууллага

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### “ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр

тасалбар болгосон санхүүгийн тайлан

Улаанбаатар хот

2026 он

**АГУУЛГА**

**ХУУДАС**

|                                                         |       |
|---------------------------------------------------------|-------|
| Компанийн талаарх мэдээлэл.....                         | 2     |
| Хараат бус аудиторын тайлан.....                        | 3-4   |
| Санхүүгийн байдлын тайлан.....                          | 5     |
| Ашиг, алдагдал, орлогын тайлан.....                     | 6     |
| Өмчийн өөрчлөлтийн тайлан.....                          | 7     |
| Мөнгөн гүйлгээний тайлан .....                          | 8     |
| Тайлагнагчийн мэдээлэл.....                             | 9     |
| Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй..... | 9-15  |
| Санхүүгийн тайлангийн тодруулгууд.....                  | 15-17 |
| Гэрээт ажлын захидал.....                               | 18-19 |

**“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК-ийн товч мэдээлэл:**

**Гүйцэтгэх захирал:** Б.Сугарсүрэн

**Хувьцаа эзэмшигчид:** 15

**Албан ёсны хаяг:** Монгол Улс, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
олимп, реженс барилга  
204 тоот

**Аудитын компани:** Сэрэлт Дөл Аудит ХХК

**Үйл ажиллагааны зөвшөөрөл:** Аудит баталгаажуулалтын үйл ажиллагааны **23-2015**  
дугаарын тусгай зөвшөөрөлтэй.

**Албан ёсны хаяг:** УБ хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Сүхбаатарын  
гудамж, Peace building . 302 тоот



“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,  
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот  
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;

Цахим шуудан: altantsetseg@sdaudit.mn

2026.03.17

№

СТА/26-55

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Дүгнэлт

Бид “Люкс Занаду Групп” ХК-ний 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн тайлант жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “НБЁЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

### Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

**Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгөхгүй юм.

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог. Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор зохих байгууллагаас гаргасан хууль, дүрэм, журмын даган мөрдөлтийн талаар тест гүйцэтгэсэн бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөөгүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 95.1-р зүйлд заасны дагуу зөвхөн “Люкс Занаду Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулахад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

**СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК**  
Мэргэшсэн нягтлан бодогчид

Монгол Улс, Улаанбаатар хот  
Огноо: 2026 оны 03 сарын 17.



**Д.АЛТАНЦЭЦЭГ**  
Захирал, ММНБ

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

|                                                |                  |                             | Аудитлагдсан                |  |
|------------------------------------------------|------------------|-----------------------------|-----------------------------|--|
| <u>Үзүүлэлт</u>                                | <u>Тодруулга</u> | <u>2024.12.31</u>           | <u>2025.12.31</u>           |  |
| <b>Хөрөнгө</b>                                 |                  |                             |                             |  |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө                | 4                | 337,896.59                  | 37,896.59                   |  |
| Дансны авлага                                  | 5                | 13,258,299.41               | 12,258,299.41               |  |
| Татвар НДШ-ийн авлага                          | 6                | 154,504.00                  | 154,504.00                  |  |
| Бусад авлага                                   |                  |                             |                             |  |
| Бараа материал                                 |                  |                             |                             |  |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо                  |                  |                             |                             |  |
| <b><u>Эргэлтийн хөрөнгийн дүн</u></b>          |                  | <b><u>13,750,700.00</u></b> | <b><u>12,450,700.00</u></b> |  |
| Үндсэн хөрөнгө                                 | 7                | 16,174,500.00               | 12,939,600.00               |  |
| Биет бус хөрөнгө                               |                  |                             |                             |  |
| <b><u>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</u></b>      |                  | <b><u>16,174,500.00</u></b> | <b><u>12,939,600.00</u></b> |  |
| <b><u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</u></b>               |                  | <b><u>29,925,200.00</u></b> | <b><u>25,390,300.00</u></b> |  |
| Дансны өглөг                                   |                  |                             |                             |  |
| Татварын өр                                    |                  |                             |                             |  |
| НДШ-ийн өглөг                                  |                  |                             |                             |  |
| Урьдчилж олсон орлого                          |                  |                             |                             |  |
| <b><u>Богино хугацаат өр төлбөрийн дүн</u></b> |                  |                             |                             |  |
| Урт хугацаат зээл                              |                  |                             |                             |  |
| <b><u>Урт хугацаат өр төлбөрийн дүн</u></b>    |                  |                             |                             |  |
| <b><u>Нийт өр төлбөрийн дүн</u></b>            |                  |                             |                             |  |
| <b><u>Өмч</u></b>                              |                  |                             |                             |  |
| Хувийн                                         | 8                | 8,287,100.00                | 8,287,100.00                |  |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл            |                  | 34,714,500.00               | 34,714,500.00               |  |
| Хуримтлагдсан ашиг                             |                  | -13,076,400.00              | -17,611,300.00              |  |
| <b><u>Эздийн өмчийн дүн</u></b>                |                  | <b><u>29,925,200.00</u></b> | <b><u>25,390,300.00</u></b> |  |
| <b><u>ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</u></b>          |                  | <b><u>29,925,200.00</u></b> | <b><u>25,390,300.00</u></b> |  |

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

| <u>Үзүүлэлт</u>                                     | <u>Тодруулга</u> | <u>2024.12.31</u>           | <u>Аудитлагдсан<br/>2025.12.31</u> |
|-----------------------------------------------------|------------------|-----------------------------|------------------------------------|
| <b><u>Борлуулалтын орлого (цэвэр)</u></b>           | 9                | <b><u>6,000,000.00</u></b>  |                                    |
| Борлуулалтын өртөг                                  |                  |                             |                                    |
| <b><u>Нийт ашиг /алдагдал/</u></b>                  |                  | <b><u>6,000,000.00</u></b>  |                                    |
| Түрээсийн орлого                                    |                  |                             |                                    |
| Хүүний орлого                                       |                  |                             |                                    |
| Бусад орлого                                        |                  |                             |                                    |
| Борлуулалт, маркетингийн зардал                     |                  |                             |                                    |
| Ерөнхий ба удирдлагын зардал                        | 10               | 14,399,600.00               | 4,534,900.00                       |
| Санхүүгийн зардал                                   |                  |                             |                                    |
| Бусад зардал                                        |                  |                             |                                    |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)          |                  |                             |                                    |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)          |                  |                             |                                    |
| Бусад ашиг (алдагдал)                               |                  |                             |                                    |
| <b><u>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</u></b> |                  | <b><u>-8,399,600.00</u></b> | <b><u>-4,534,900.00</u></b>        |
| Орлогын татварын зардал                             |                  |                             |                                    |
| <b><u>Татварын дараах ашиг (алдагдал)</u></b>       |                  | <b><u>-8,399,600.00</u></b> | <b><u>-4,534,900.00</u></b>        |
| <b><u>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</u></b>   |                  |                             |                                    |
| <b><u>Орлогын нийт дүн</u></b>                      |                  | <b><u>-8,399,600.00</u></b> | <b><u>-4,534,900.00</u></b>        |
| <b><u>Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)</u></b> |                  |                             |                                    |

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Үзүүлэлт                                                                     | Өмч                 | Хөрөнгийн<br>дахин<br>үнэлгээний<br>нэмэгдэл | Хуримтлагдсан<br>ашиг | Дүн                  |
|------------------------------------------------------------------------------|---------------------|----------------------------------------------|-----------------------|----------------------|
| <b>2023 оны 01 сарын 01-ний<br/>үлдэгдэл</b>                                 |                     |                                              |                       |                      |
| <b>Залруулсан үлдэгдэл</b>                                                   | 6,310,900.00        | 34,714,500.00                                | -4,676,800.00         | <b>36,348,600.00</b> |
| Тайлант үеийн цэвэр ашиг,<br>алдагдал                                        |                     |                                              | -8,399,600.00         | <b>-8,399,600.00</b> |
| Өмчид гарсан өөрчлөлт                                                        | 1,976,200.00        |                                              |                       | 1,976,200.00         |
| <b>2024 оны 12 сарын 31-ний<br/>үлдэгдэл</b>                                 | <b>8,287,100.00</b> | <b>34,714,500.00</b>                         | <b>-13,076,400.00</b> | <b>29,925,200.00</b> |
| Нягтлан бодох бүртгэлийн<br>бодлогын өөрчлөлтийн нөлөө,<br>алдааны залруулга |                     |                                              |                       |                      |
| <b>Залруулсан үлдэгдэл</b>                                                   | 8,287,100.00        | 34,714,500.00                                | -13,076,400.00        | <b>29,925,200.00</b> |
| Тайлант үеийн цэвэр ашиг,<br>(алдагдал)                                      |                     |                                              | -4,534,900.00         | <b>-4,534,900.00</b> |
| Өмчид гарсан өөрчлөлт                                                        |                     |                                              |                       |                      |
| <b>2025 оны 12 сарын 31-ний<br/>үлдэгдэл</b>                                 | <b>8,287,100.00</b> | <b>34,714,500.00</b>                         | <b>-17,611,300.00</b> | <b>25,390,300.00</b> |

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/төгрөгөөр/

| <b>ҮЗҮҮЛЭЛТ</b>                                         | <b>2024.12.31</b>           | <b>2025.12.31</b>           |
|---------------------------------------------------------|-----------------------------|-----------------------------|
| <b>Мөнгөн орлогын дүн (+)</b>                           |                             |                             |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого            |                             |                             |
| Буцаан авсан албан татвар                               |                             |                             |
| Бусад мөнгөн орлого                                     |                             |                             |
| <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>                          | <b><u>4,014,304.00</u></b>  | <b><u>1,300,000.00</u></b>  |
| Ажиллагчдад төлсөн                                      |                             |                             |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн                  |                             |                             |
| Бараа материал худалдан авахад төлсөн                   |                             |                             |
| Ашиглалтын зардалд төлсөн                               |                             |                             |
| Хүүний төлбөрт төлсөн                                   |                             |                             |
| Бусад мөнгөн зарлага                                    | 4,014,304.00                | 1,300,000.00                |
| <b>ҮҮАжиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний</b>            | <b><u>-4,014,304.00</u></b> | <b><u>-1,300,000.00</u></b> |
| <b>Мөнгөн орлогын дүн (+)</b>                           | <b><u>1,976,200.00</u></b>  |                             |
| Хүлээн авсан хүүний орлого                              |                             |                             |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаалт        | 1,976,200.00                |                             |
| <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>                          |                             |                             |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                     |                             |                             |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                   |                             |                             |
| <b>ХО-ын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>       | <b><u>1,976,200.00</u></b>  |                             |
| <b>Мөнгөн орлогын дүн (+)</b>                           |                             | <b><u>1,000,000.00</u></b>  |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан     |                             | 1,000,000.00                |
| Бусад мөнгөн орлого                                     |                             |                             |
| <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>                          |                             |                             |
| Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн                   |                             |                             |
| Бусад мөнгөн зарлага                                    |                             |                             |
| <b>СҮАжиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>              |                             | <b><u>1,000,000.00</u></b>  |
| Валютын ханшийн зөрүү                                   |                             |                             |
| <b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>                         | <b><u>-2,038,104.00</u></b> | <b><u>-300,000.00</u></b>   |
| <b>Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>  | <b><u>2,376,000.59</u></b>  | <b><u>337,896.59</u></b>    |
| <b>Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b> | <b><u>337,896.59</u></b>    | <b><u>37,896.59</u></b>     |

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

## 1. КОМПАНИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

“Люкс Занаду Групп” ХК (цаашид “Компани” гэх) нь доорх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй. Үүнд:

- Гадаад худалдаа
- Мэдээллийн технологи
- Интернет, цахим хуудасны үйлчилгээ
- Аялал жуулчлал
- Бизнесийн зөвөлгөө өгөх
- Зар сурталчилгаа

Компани нь 2009 оны 07 сарын 09-нд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үүсгэн байгуулагдсан хувьцаат компани юм.

Албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, олимп, реженс барилга 204 тоот албан ёсны хаяг дээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Улсын бүртгэлийн дугаар: 9010001091 тоот

Регистрийн дугаар: 2050153 тоот

**Өмчийн хэлбэр:** Компани нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг 15 гишүүнтэй байгууллага.

**Тайланг хамарсан хугацаа:** 2025 оны 1 дүгээр сарын 1-нээс 2025 оны 12 дугаар сарын 31

## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Хүраангуй

### 2.1 Мөрдсөн стандарт

Компанийн санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын (СТОУС) дагуу бэлтгэж, тайлагнасан болно.

### 2.2 Тайлан бэлтгэх үндэслэл тайлангийн суурь

Компанийн санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын (СТОУС) дагуу бэлтгэж, тайлагнасан болно.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Компанийн үйл ажиллагааны үндсэн мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлсэн.

### 2.3 Тасралтгүй байх зарчим

2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Компанийн эргэлтийн хөрөнгө нь 0.00 төгрөг (2024: 0.00) төгрөг байна. Компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадвар нь ирээдүйн ашигтай үйл ажиллагаа, эерэг мөнгөн урсгал ба эсвэл хувь нийлүүлэгчдээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх эсэхээс хамаарна.

## 2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогод орсон өөрчлөлт

2025 оны 1 сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа доорх стандарт болон стандартын нэмэлт өөрчлөлтүүдээс бусад тохиолдолд өмнөх санхүүгийн жилд мөрдөж байсан бүртгэлийн бодлогуудаа энэ санхүүгийн жилд тууштай мөрдөж байгаа болно.

| Хэрэгжих хугацаа | Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд                                                                                                                                          |
|------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 2025.01.01       | СТОУС-16 Түрээс<br>Борлуулах ба буцаан түрээслэхтэй холбоотой хувьсах төлбөрийн өөрчлөлт                                                                                    |
| 2025.01.01       | НББОУС-1 Санхүүгийн тайлангийн тодруулга<br>Эргэлтийн ба эргэлтийн бус өр төлбөрийн ангилал, эргэлтийн бус өр төлбөрийн гэрээгээр хүлээх үүрэг хариуцлагын талаарх өөрчлөлт |
| 2025.01.01       | НББОУС-7 Мөнгөн гүйлгээний тайлан, СТОУС-7 Санхүүгийн хэрэглүүр:<br>Тодруулга Нийлүүлэгчийн санхүүжилтийн зохицуулалтын нэмэлт өөрчлөлтүүд                                  |
| 2025.01.01       | СТОУС-ТБ1 Тогтвортой байдалд хамаарах санхүүгийн мэдээллийг тодруулах ерөнхий шаардлага                                                                                     |
| 2025.01.01       | НББОУС-21 Гадаад валютын ханшийн үр нөлөө Арилжааны алдагдлын талаарх нэмэлт өөрчлөлт                                                                                       |

Захирлууд эдгээр стандарт болон тайлбаруудыг хэрэгжүүлснээр ирээдүйд Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэсэн хүлээлттэй байна.

## 2.5 Гадаад валютын өөрчлөлт

Компаний санхүүгийн тайлан нь мөнгөн нэгж болох Монгол төгрөгөөр илэрхийлэгдсэн байна. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгж рүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн (Монгол банк)-ны ханшаар дахин хөрвүүлдэг.

Төгрөгийн нэгж ам доллортой харьцах ханш 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1 ам долларт = 3,556.81 төгрөг (2024: 1 ам долларт=3,420.46).

## 2.6 Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрвэл тухайн хөрөнгийн бүртгэлийн үнэ нь үнэ цэнийн бууралтад орсон эсэхийг тооцоолж үзнэ. Хэрэв үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн тооцоолсон нөхөн төлөгдөх дүнг боддог. Нөхөн төлөгдөх дүн нь цэвэр үнээс борлуулах өртгийг хассан дүн ба хөрөнгийн ашиглалтын үнийн аль ихээр тодорхойлогдоно.

## 2.7 Санхүүгийн хөрөнгө

*Анхлан хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*

Анхлан хүлээн зөвшөөрөлтийн үед санхүүгийн хөрөнгийн ангилал нь тухайн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанар ба Компанийн хөрөнгийг удирдах бизнесийн загвараас хамаарна.

Компани нь санхүүгийн томоохон бүрэлдэхүүн хэсэг агуулаагүй худалдааны авлагаас бусад санхүүгийн хөрөнгийг анхлан бодит үнэ цэнээр нь хэмжиж, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар илэрхийлэгдэх хөрөнгөөс бусад хөрөнгийн бодит үнэ дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр хэмжинэ. Санхүүгийн томоохон бүрэлдэхүүн хэсэг агуулаагүй эсвэл Компани практик арга барилыг хэрэгжүүлсэн худалдааны авлагыг арилжааны үнээр хэмждэг.

Компанийн санхүүгийн хөрөнгүүд нь бэлэн мөнгө ба банкин дах данс, худалдааны болон бусад авлагаас бүрдэнэ. Эдгээр санхүүгийн хөрөнгүүд нь зээл ба авлагууд гэж ангилагдах бөгөөд хорогдуулсан өртгөөр хэмжигдэнэ.

#### *Дараа үеийн хэмжилт*

Зээл болон авлагууд нь идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй, үүсмэл биш санхүүгийн хөрөнгүүд юм. Эдгээр санхүүгийн хөрөнгүүдийн анхлан хүлээн зөвшөөрснөөс хойш үнэ цэнийн бууралтыг хасаж үр ашигт хүүний арга (“ҮАХТ”) ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Хорогдуулсан өртгийг ҮАХТ-ий салшгүй хэсэг болох худалдан авалтын хөнгөлөлт, урамшуулал, шимтгэл зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр тооцдог.

#### *Үл хүлээн зөвшөөрөлт*

Санхүүгийн хөрөнгийг тухайн санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөн гүйлгээг авах эрхийн хүчинтэй хугацаа дууссан эсвэл уг санхүүгийн хөрөнгийн өмчлөлийн бараг бүх эрсдэл болон өгөөжийг шилжүүлсэн тохиолдолд үл хүлээн зөвшөөрдөг.

#### *Үнэ цэнийн бууралт*

Компани зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын загварыг бүх санхүүгийн хөрөнгөд ашигладаг. Компани нь томоохон санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсгийг агуулаагүй худалдааны авлага ба гэрээний хөрөнгийг ҮЦХБА-ын хялбаршуулсан аргачлалаар тооцдог. Бусад санхүүгийн хөрөнгүүдэд, үнэ цэнийн бууралт нь ЗҮЦХА-ийг 2 үе шатаар хүлээн зөвшөөрдөг ерөнхий аргачлалын дагуу тооцдог. ЗҮЦХА загварын дагуу, аж ахуйн нэгжүүд хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт ажиглагдаагүй үед зээлийн үнэ цэнийн 12 сарын хугацаанд хүлээгдэж буй алдагдлыг (“ЗҮЦ12сХА”) ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

## **2.8 Санхүүгийн өр төлбөр**

#### *Анх хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*

Санхүүгийн өр төлбөрийг аль зохистой ангилалд нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх, зээл ба зээллэг, эсвэл үр нөлөөтэй хейджингийн хэрэглүүрээр анх хүлээн зөвшөөрнө.

#### *Дараах үеийн хэмжилт*

Санхүүгийн өр төлбөрийн дараах үеийн хэмжилт нь доор дурдсан ангиллаас шалтгаална:

##### *Зээл ба зээллэг*

Анх хэмжсэний дараа, зээл ба зээллэгийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх үед

болон үр ашигт хүүг ашиглан хорогдуулах үеийн олз, гарзыг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

*Үл хүлээн зөвшөөрөлт*

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг.

## **2.9 Санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ**

Хэмжилтийн өдөр зах зээлийн оролцогчдын хооронд зохих журмын дагуу хийгдэж буй гүйлгээний үед хөрөнгө борлуулахад хүлээн авч буй эсвэл өр төлбөрийг шилжүүлэхэд төлж буй үнийг бодит үнэ цэнэ гэнэ.

Бодит үнэ цэнийн хэмжилт нь дараах тохиолдлуудад болж буй хөрөнгийг борлуулах болон өр төлбөрийг шилжүүлэх гүйлгээний таамаглалд үндэслэдэг. Үүнд:

- Хөрөнгө, өр төлбөрийн үндсэн зах зээлд эсвэл
- Үндсэн зах зээл байхгүй үед хөрөнгө, өр төлбөрийн хамгийн давуу зах зээлд

Компани үндсэн болон давуу зах зээлд оролцох боломжтой байх ёстой.

## **2.10 Энгийн хувьцаа**

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгийн ангилалд оруулах ба нэрлэсэн үнээр бүртгэнэ. Шинэ хувьцаа гаргахтай шууд холбоотой нэмэлт зардлыг хувьцаа борлуулсны татварын дараах орлогоос хасах дүнгээр эздийн өмчийн дүнд тусгадаг.

Энгийн хувьцааны ногдол ашгийг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх ба Компанийн хувьцаа эзэмшигчид баталсан үед өөрийн хөрөнгөөс хасна. Хугацааны дундуур ногдол ашиг зарласан, Компани буццах эрхгүй болсон үед өөрийн хөрөнгөөс хасна.

## **2.11 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

Санхүүгийн байдлын тайланд бэлэн мөнгө ба банкны үлдэгдэл нь банкинд бэлэн мөнгөөр хийгддэг. Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгөн хөрөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө ба үнэ цэнэ нь өөрчлөгдөх эрсдэл багатай банкуудад хамаарна

## **2.12 Хуримтлагдсан ашиг**

Хуримтлагдсан ашиг, алдагдал нь хуримтлагдсан ашиг эсвэл алдагдлаас зарласан ноогдол ашгийг хассан дүнг илэрхийлнэ.

## **2.13 Болзошгүй үйл явдлууд**

Санхүүгийн тайланд болзошгүй өр төлбөрүүдийг хүлээн зөвшөөрдөггүй. Эдийн засгийн үр өгөөж агуулсан эх үүсвэр гадагшлах магадлал бага биш бол эдгээр өр төлбөрийн талаар санхүүгийн тайланд тодруулга хийнэ. Санхүүгийн тайланд болзошгүй хөрөнгүүдийг хүлээн зөвшөөрөхгүй боловч эдийн засгийн өгөөж орж ирэх нь магадлалтай болсон үед санхүүгийн тайланд тодруулга хийнэ.

## **2.14 Тайлант хугацааны дараах үйл явдлууд**

Тайлант хугацааны эцэс дэх Компанийн санхүүгийн байдлын талаар нэмэлт мэдээлэл өгөх тайлант хугацааны дараах үйл явдлууд (залруулах үйл явдлууд)-ыг санхүүгийн тайланд оруулж тайлагнана.

Залруулах бус тайлант хугацааны дараах үйл явдал нь материаллаг дүнтэй бол санхүүгийн тайлангийн тодруулгад оруулж мэдээлнэ.

### 2.15 Холбоотой талууд

Холбоотой тал гэдэг нь: Компанитай холбоотой этгээд юмуу эсвэл компани юм.

Тухайн хүний эсвэл тухайн хүний гэр бүлийн гишүүн нь Компанид хамааралтай бол:

- ✓ Компанийн хяналт эсвэл хамтын хяналттай;
- ✓ Компанид мэдэгдэхүйц нөлөөтэй;
- ✓ Компанийн гол удирдах боловсон хүчин эсвэл компанийн нэгдмэл гишүүн

Байгууллага нь дараахь нөхцлүүдийн аль нэгийг мөрдөж байвал дараахь аж ахуйн нэгжтэй холбоотой байна:

- Байгууллага ба Компани нь нэг группын гишүүд (өөрөөр хэлбэл, толгой компани болон охин компани нь бусадтай холбоотой) гэсэн үг юм
- Нэг аж ахуйн нэгж нь бусад аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр (эсвэл бусад аж ахуйн нэгжийн гишүүн байх булгээр ажилладаг хараат компани эсвэл хамтарсан компани) юм
- Аливаа аж ахуйн нэгж нь гуравдагч этгээдийн хамтарсан компани юм
- Нэг аж ахуйн нэгж гуравдагч этгээдийн хамтарсан компани бөгөөд бусад аж ахуйн нэгж нь гуравдагч этгээдийн хараат компани юм
- Аж ахуйн нэгж нь Компанитай холбоотой аж ахуйн нэгжийн аль алиных нь ажилтнуудын ашиг тусын төлөө ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө юм. Компани өөрөө ийм төлөвлөгөөтэй байгаа бол ивээн тэтгэгч ажил олгогч нь компанитай холбоотой.
- Байгууллага нь Компанийн хяналт, хамтарсан хяналттай этгээдийн хяналтанд эсвэл хамтран хяналт тавьдаг.

### 2.16 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тооцож тусгана. Үндсэн хөрөнгийн анхны өртөгт худалдан авсан үнэ, импортын татвар, татварууд болон хөрөнгийг ашиглалтанд оруулахтай холбогдон гарсан шууд зардлууд орно.

Үндсэн хөрөнгө анх үнэлж байсан стандарт гүйцэтгэлээс илүү гарч түүнийг ашиглахтай холбогдон гарсан зардал ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг өсгөсөн нь тодорхой болсон бол зардлыг үндсэн хөрөнгийн нэмэлт өртгөөр капиталжуулна.

Хөрөнгийг борлуулах болон данснаас хасах үед тухайн хөрөнгийн өртөг, хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын дүнг оролцуулан данснаас хасах бөгөөд үүнээс үүсэх аливаа олз, гарзыг тайлант жилийн орлого, үр дүнгийн тохирох хэсэгт бүртгэнэ.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар элэгдүүлдэг. Үүнд:

| д/д | Дансны ангилал                                                                                                            | Ашиглагдах жил                |    |
|-----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------|----|
| 1.  |                                                                                                                           | 40                            | 25 |
| 2   | Машин, механизм, техник, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж                                                                    | 10                            |    |
| 3   | Компьютер, дагалдах тоног төхөөрөмж, программ хангамж                                                                     | 2                             |    |
| 4   | Ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө /Үүнд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хамаарна./ | Хүчин төгөлдөр байх хугацаанд |    |
| 5   | Бусад хөрөнгө                                                                                                             | 10                            |    |

### 2.17 Биет бус хөрөнгө

Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт (ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцно.) болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.

Биет бус хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз, гарз нь цэвэр борлуулалтын орлого болон хөрөнгийн бүртгэлийн үнийн зөрүүгээр хэмжигдэх ба олз, гарзыг биет бус хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн үед орлого, зардлын дансанд бүртгэнэ. Компанийн биет бус хөрөнгө нь компьютерийн программ хангамжийн лицензүүд байх бөгөөд хүлээгдэж буй гурваас (3) арван (10) жилийн хугацаанд шулуун шугамын аргыг ашиглан хорогдуулна.

## 3. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, төсөөллүүд

НББОУС-ын дагуу санхүүгийн тайлангуудыг бэлтгэх ажил нь удирдлагаас тайлагналын өдрийн байдлаарх орлого, зардал, хөрөнгө, өр төлбөрийн тайлагнасан дүн ба болзошгүй өр төлбөрийн тодруулга зэрэгт нөлөө үзүүлэх үнэлэмж, ойролцоолсон тооцоолол, төсөөллүүдийг хийхийг шаарддаг. Гэвч эдгээр төсөөлөл, тооцооллуудын тодорхой бус байдал нь ирээдүйд хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дунд материаллаг дүнтэй залруулга хийхэд хүргэж болно..

### 3.1 Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж

#### 3.1.1 Монгол Улсын татварын систем

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монголын Засгийн Газар бизнес болон эдийн засгийн бүтцэд өөрчлөлт шинэчлэлтийг хийсээр байна. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.

Өөр, өөр эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг.

### 3.2 Тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж

Тайлан тэнцлийн өдрийн байдлаар хийгдсэн, дараагийн тайлант жилд хөрөнгийн бүртгэлийн дүнд материаллаг залруулга хийхэд хүргэж болзошгүй тооцооллуудын тодорхой бус байдлын ирээдүйн болон бусад томоохон эх үүсвэрүүдийн талаарх гол төсөөллүүдийг дор дурьдав.

#### 3.2.1 Удаан гүйлгээтэй бараа материалын хасагдуулгын нөөц

Компанийн удирдлага удаан гүйлгээтэй, зарагддаггүй болон эвдэрч гэмтсэн бараа материалыг тодорхой хугацаагаар хянадаг ба үнэлэмж болон тооцооллыг ашигладаг. Эдгээр тооцооллоос хамаарч бараа материалын үнэлгээ өөрчлөгдөх боломжтой.

#### 3.2.2 Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойлох

Компани нь үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн ашиглалтын жилийн тооцооллыг санхүүгийн тайлангийн өдрөөр хянадаг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай бол залруулдаг.

Тайлант жилийн эцэст үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцоололд өөрчлөлт гараагүй. Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг тооцоолоход үнэлэмж ашигладаг ба уг тооцоолол нь тайлант жилийн цэвэр ашигт нөлөө үзүүлэх боломжтой.

Удирдлага дээрх тооцоолсон үндсэн хөрөнгийн ашиглалтын жил уг хөрөнгийн бодитой эдийн засгийн ашиглах жил гэдэгт итгэж байна.

### Санхүүгийн тайлагналын тэмдэглэл

#### 4. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

|                       |                   | /төгрөгөөр/      |
|-----------------------|-------------------|------------------|
| Үзүүлэлт              | 2024.12.31        | 2025.12.31       |
| Касс дахь бэлэн мөнгө | 337,896.59        | 37,896.59        |
| Банкны харилцах данс  |                   |                  |
| <b>Нийт дүн</b>       | <b>337,896.59</b> | <b>37,896.59</b> |

Тайлант оны мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл нь өмнөх оны мөн үеэс -300,000 төгрөг буюу 88.7%-иар буурсан үзүүлэлттэй байна.

#### 5. Дансны авлага

|                 |                      | /төгрөгөөр/          |
|-----------------|----------------------|----------------------|
| Үзүүлэлт        | 2024.12.31           | 2025.12.31           |
| Дансны авлага   | 13,258,299.41        | 12,258,299.41        |
| Бусад авлага    |                      |                      |
| <b>Нийт дүн</b> | <b>13,258,299.71</b> | <b>12,258,299.41</b> |

Дансны авлага нь барьцаагүй, хүүгүй бөгөөд ерөнхийдөө ерэн (90) хоногийн дотор буюу төлөгддөг. Хугацаа хэтэрсэн авлагад хүү тооцдоггүй. Авлага нь анхны нэхэмжлэхийн үнээр буюу бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгддөг.

## 6. Татвар, НДШ-ийн авлага

| Үзүүлэлт         | /төгрөгөөр/       |                   |
|------------------|-------------------|-------------------|
|                  | 2024.12.31        | 2025.12.31        |
| ААНОАТ-ын авлага |                   |                   |
| НӨАТ-ийн авлага  |                   |                   |
| НДШ-ийн авлага   |                   |                   |
| Бусад төрөл      | 154,504.00        | 154,504.00        |
| <b>Нийт дүн</b>  | <b>154,504.00</b> | <b>154,504.00</b> |

## 7. Үндсэн хөрөнгө

|                               | /төгрөгөөр/       |                       |                      |
|-------------------------------|-------------------|-----------------------|----------------------|
|                               | Тавилга эд хогшил | Машин тоног төхөөрөмж | Бусад үндсэн хөрөнгө |
| <b>Үндсэн хөрөнгө /өртөг/</b> |                   |                       |                      |
| Эхний үлдэгдэл                |                   |                       | 32,349,000.00        |
| Нэмэгдсэн                     |                   |                       |                      |
| Эцсийн үлдэгдэл               |                   |                       | 32,349,000.00        |
| <b>Хуримтлагдсан</b>          |                   |                       |                      |
| Эхний үлдэгдэл                |                   |                       | 16,174,500.00        |
| Нэмэгдсэн дүн                 |                   |                       | 3,234,900.00         |
| Эцсийн үлдэгдэл               |                   |                       | 19,409,400.00        |
| <b>Дансны цэвэр дүн</b>       |                   |                       |                      |
| Эхний үлдэгдэл                |                   |                       | 16,174,500.00        |
| Эцсийн үлдэгдэл               |                   |                       | 12,939,600.00        |

НББОУС 16-д зааснаар Үндсэн хөрөнгийн солилцоо болон буцалтгүй тусламжаар авсан хөрөнгийг бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Бусад тохиолдолд анхны өртгөөр нь бүртгэнэ. Компани үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцдог.

## 8. Хувьцаат капитал

2024 болон 2025 онуудын 12-р сарын 31-нээрх хувьцаат капитал:

| Үзүүлэлт                      | Хувьцаа /тоогоор/ |            | Капитал /төгрөгөөр/ |                     |
|-------------------------------|-------------------|------------|---------------------|---------------------|
|                               | 2024.12.31        | 2025.12.31 | 2024.12.31          | 2025.12.31          |
| Нэмэгдсэн                     |                   |            |                     |                     |
| <b>Батлагдсан ба гаргасан</b> |                   |            | <b>6,310,900.00</b> | <b>8,287,100.00</b> |

**9. Борлуулалтын орлого**

/төгрөгөөр/

| Үзүүлэлт                                    | 2024.12.31                 | 2025.12.31         |
|---------------------------------------------|----------------------------|--------------------|
| Ажил, үйлчилгээ борлуулсны орлого           | 6,000,000.00               | 0.00               |
| <b><u>Борлуулалтын орлогын нийт дүн</u></b> | <b><u>6,000,000.00</u></b> | <b><u>0.00</u></b> |

Тайлант оны эцсийн борлуулалтын орлогын үлдэгдэл нь өмнөх оны мөн үеэс 6,000,000.00 төгрөг буюу 100%-иар буурсан үзүүлэлттэй байна.

**10. Борлуулалт маркетингийн болон ерөнхий удирдлагын зардал**

/төгрөгөөр/

| Үзүүлэлт                       | 2024.12.31                  | 2025.12.31                 |
|--------------------------------|-----------------------------|----------------------------|
| Цалингийн зардал               |                             |                            |
| НДШ-ийн зардал                 |                             |                            |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | 1,460,000.00                | 1,300,000.00               |
| Засварын зардал                |                             |                            |
| Элэгдэл, хорогдлын зардал      | 12,939,600.00               | 3,234,900.00               |
| Бусад                          |                             |                            |
| <b><u>Нийт дүн</u></b>         | <b><u>14,399,600.00</u></b> | <b><u>4,534,900.00</u></b> |

**11. Капиталын удирдлага**

Компанийн хөрөнгийн удирдлагын үндсэн зорилго нь өөрийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих, өр төлбөрөө барагдуулах ба хувь нийлүүлэгчдийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

Компани өөрийн хөрөнгийн бүтцийг удирдан, өөрчлөлт хийхдээ эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулдаг. Хөрөнгийн бүтцийг хэвийн хадгалах эсвэл өөрчлөхийн тулд Компани хувьцаа эзэмшигчдэд төлөх ногдол ашгийн хэмжээг тохируулан тогтоох, хувьцаагаа хувьцаа эзэмшигчдэд буцааж өгөх эсвэл шинэ хувьцаа гаргах зэрэг арга замыг ашиглах боломжтой.

**12. Тайлагналын өдрийн дараах үйл явдал**

Тайлангийн дараа онцлох үйл явдал гараагүй болно.



“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК-ний  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
ТАНАА

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,  
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот  
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;

Цахим шуудан: altantsetseg@sdaudit.mn

2026.03.17

№

ГАЗ/26-55

танай

-ны №

-т

ГЭРЭЭТ АЖЛЫН ЗАХИДАЛ

“Люкс Занаду Групп” ХК болон “Сэрэлт Дөл Аудит” ХХК-ний хооронд байгуулсан гэрээ (хэлцэл)-д танай компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр гаргасан санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийхээр харилцан тохиролцсон билээ.

Манай талаас үзүүлэх аудитын үйлчилгээний зорилт нь санхүүгийн тайлангуудад дүгнэлт өгөх явдал юм. Бид аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу явуулсан болно.

Санхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэдэг үндэслэлтэй нотолгоо олж авах зорилгоор аудитын ажлыг төлөвлөж, гүйцэтгэхийг уг АОУС-д заасан байдаг. Аудитын явцад санхүүгийн тайлан дахь дүн, нэмэлт тодруулгууд нь зөв эсэхийг нотлоход тестийн аргыг хэрэглэсэн.

Түүнчлэн тус компанид хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, удирдлагын хийсэн томоохон хэмжээний тооцооллууд, түүнчлэн санхүүгийн тайлагналын байдалд бүхэлд нь үнэлэлт өгнө.

Аудитын тестийн арга болон бусад уламжлалт хязгаарлагдмал шинж чанар, түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн ба дотоод хяналтын системийн ямар нэг уламжлалт хязгаарлагдмал байдлын улмаас зарим материаллаг зөрчлийг ч илрүүлэхгүй байх болон зарим алдаатай зүйлс гарах магадлал байхыг бид үгүйсгэхгүй.

Гэхдээ ийм төрлийн алдааг аль болохоор хамгийн бага байлгахаар бид аудитын ажлыг төлөвлөж явуулсан.

Бид жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ба хараат бус аудитын тайланг нэмэлт тодруулгын хамт хүргүүлж, нягтлан бодох бүртгэл, хууль эрх зүйн орчны нийцтэй байдлыг тусгасан, дотоод хяналтын системийн эрсдэлтэй сул талыг үнэлж, цаашид засаж сайжруулах талаар дэлгэрэнгүй зөвлөмжийг бичиж, гэрээний хугацаанд компанийн удирдлагад хүргүүлж байна.

Зохих нэмэлт тодруулга бүхий санхүүгийн тайланг бэлтгэх нь компанийн удирдлагын хүлээх хариуцлага гэдгийг бид сануулахыг хүсч байна.

Үүнд, нягтлан бодох бүртгэлийн зохих бичилт болон дотоод хяналтыг хангах, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож хэрэглэх, байгууллагын хөрөнгийг найдвартайгаар хадгалах, хамгаалах, нөөцийг үр ашигтай зарцуулах зэрэг зүйлс багтана.

Аудитад хамрагдах санхүүгийн болон бусад бүх мэдээллийн үнэн, зөвийн баталгааг бичгээр гаргаж өгөхийг бид хүсэлт гарган хүлээн авч, холбогдох дансдын үлдэгдлийг баталгаажуулах захидал илгээж баталгаажуулсан болно.

Бид танай хамт олонтой хамтран ажиллах чин эрмэлзэлтэй байсан бөгөөд аудиттай холбоотой бидний хүссэн аливаа бүртгэл, баримт, бусад мэдээллээр биднийг хангаж өгч ажилласанд талархаж байна.

Санхүүгийн тайлангийн аудитын ажлыг та хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлэн энд гарын үсгээ зурж манай талд ирүүлнэ үү.

“СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ” ХХК-ний

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК-ний

Захирал, Партнер: Д.Алтанцэцэг

Гүйцэтгэх захирал:

Б.Сугарсүрэн

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Нягтлан бодогч:

Б.Болорцэцэг



/...../

/...../